



**НООС БОЛОВСРУУЛАХ, НООСОН БОРДООНЫ ҮЙЛДВЭРИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ, ТЭЗҮ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**
(Баянхонгор аймаг)

№	АЖЛЫН НЭР ТӨРӨЛ	ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын Их Хурлын 2024 оны "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоол Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Засгийн газрын 2024-2028 он үйл ажиллагааны хөтөлбөр" 3.4.23. чанар, стандартын шаардлага хангасан бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ Баянхонгор аймгийн Засаг даргын 2022-02-08 өдрийн А/23 захирамж
2	Ажлын зорилго	Тухайн аймгийн хөгжлийн боломж, ноос үйлдвэрлэлийн нөөц, боловсруулалтын түвшин, зах зээх хэрэгцээ, шаардлагад тулгуурласан ноос боловсруулах, ноосон бордооны үйлдвэрбайгуулж, орон нутагт иргэн, аж ахуйн нэгж, хоршоологчид ноос, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх таатай орчинг бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар иргэд болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах суурь нөхцөл бүрдүүлэх
3	Хэрэгцээ шаардлага	Сүүлийн жилүүдэд хөдөө, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил нийслэлээс илт хоцорч, орон нутгаас нийслэл Улаанбаатар хотыг чиглэсэн урсгал бий болж, орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж харьцангуй хязгаарлагдмал болсон нь хөгжлийн хэт ялгаатай, тэнцвэргүй байдлыг үүсгэсэн. Нөгөө талаараа орон нутагт тогтвортой бизнес эрхлэх малчдын орлогыг нэмэгдүүлдэх боломж хомсдож хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин хангалттай түвшинд хүрч чадахгүй байна. Иймд орон нутгийн онцлогт тулгуурлан эдийн засгийн нөөц чадавх, байгалийн нөөцийг бүрэн ашиглах, өртөг шингээсэн үйлдвэрлэл үйлдвэр байгуулах зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах шаардлага үүсээд байна.
4	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	- ТЭЗҮ боловсруулах – 30 хоног - Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга) – 30 хоног - Ажлын зураг, төсөв – 60 хоног - Магадлал хийлгэж баталгаажуулах – 30 хоног.
5	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	Гэрээ байгуулах үед гэрээний тусгай нөхцөлд нарийвчлан заана.
6	Хүчин чадал	ТЭЗҮ-д бүс нутгийн судалгаа хийж үйлдвэрийн хүчин чадлыг нарийвчлан тогтооно.

7	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн	<p>Өрөө тасалгаа.</p> <ul style="list-style-type: none"> - Удирдлагын өрөө - Дэд удирдлагын өрөө - Санхүүгийн албаны өрөө - Инженер техникийн албаны өрөө - Няравын өрөө - Үйлдвэрийн цех - Пресс, баглах цех - Лабораторийн өрөө - Түүхий эдийн агуулах - Бэлэн бүтээгдэхүүний агуулах - Дулаан хангамжийн өрөө - Цахилгаан хангамжийн өрөө - Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний цех - Гал тогоо - Хооллох танхим - Хувцас солих өрөө /эр, эм/ - Усанд орох өрөө /эр, эм/ - Ариун цэврийн өрөө /эр, эм/ <p>Үйлдвэрийн барилгын зураг төсөл зохиоход дараах зарчмуудыг баримтлана:</p> <p>1.1 Төрөл бүрийн үйлдвэрлэл, агуулах, захиргаа ба ахуйн үйлчилгээний өрөө тасалгаа, тэрчлэн инженерийн тоног төхөөрөмжийн өрөө тасалгааг нэг барилгад аль болох нэгтгэх;</p> <p>1.2 Барилгын өндрийг сонгохдоо үйлдвэрийг төрөл бүрийн давхар (өндөртэй)-ын барилгад байрлуулах хувилбаруудын техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцуулсан үр дүнг үндэслэх ба архитектурын шийдлийн өндөр түвшинг хангах.</p> <p>1.3 Гадна хаших бүтээцийн талбайг багасгах шаардлагыг харгалзан эзэлхүүн төлөвлөлтийн шийдэл гаргах;</p> <p>1.4 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлгийг төлөвлөх нормын дагуу байгалийн гэрэлтүүлгийн талбайг сонгох;</p> <p>1.5 Барилга, байгууламжийг гол төлөв томсгосон хэсэг, инженерийн ба технологийн тоног төхөөрөмжийн цогц хэсгүүдээр үйлдвэрийн аргаар бэлтгэх боломжтойгоор төлөвлөх.</p> <p>1.6 Хүчтэй доргион чичиргээ үүсгэгч тоног төхөөрөмж буюу гадны долгионы эх үүсвэрүүдээс барилгын бүтээц, технологийн үйл ажиллагаа, ажиллагсад үзүүлэх динамик үйлчлэлийг багасгах шаардлагыг тооцон эзэлхүүн-төлөвлөлтийн шийдэл боловсруулах.</p> <p>1.7 Барилгын архитектурын шийдлийг барилга барих нутаг дэвсгэрийн байгаль цаг уур, хот байгуулалтын нөхцөл, хүрээлэн байгаа барилгажилтын төлөв байдлыг тооцсоны үндсэн дээр гаргана. Дотор заслалын өнгөний зохицлыг үйлдвэрийн барилгын таних болон сэрэмжлүүлэх тэмдэг, дохиоллын өнгө болон аюулгүйн тэмдгүүдийн стандартын дагуу сонгох.</p> <p>2.1 Барилга байгууламж, өрөө тасалгааны тэсэрч шатах болон галын аюулын ангиллыг зохих журмаар батлагдсан тусгай жагсаалт буюу шууд харъяалал /салбар/-ын технологийн төлөвлөлтийн нормуудын дагуу зураг төслийн технологийн хэсэгт зааж өгөх.</p> <p>2.2 Галын автомат дохиолол, гал унтраах автомат тоноглол болон галын аюулын тухай зарлан мэдээлэх системийг "Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" /БНБД 21-04-05/-ын дагуу төлөвлөх.</p> <p>3.1 Өрөө, тасалгаануудын өндрийг шалнаас хучилт (хучлага)-ын бүтээцийн доод ирмэг хүртэл 2.2 м-ээс багагүй, хүмүүс байнга</p>
---	-----------------------------------	--



	<p>зорчих ба аюулын үед нүүлгэн шилжүүлэх аврах замын хэсэгт шалнаас шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн доод гадаргуу хүртэл- 2 м-ээс багагүй, харин хүмүүсийн байнга зорчихгүй хэсэгт- 1.8 м-ээс багагүйгээр төлөвлөнө.</p> <p>3.2 Барилгад авто тээврийн хэрэгсэл орох шаардлагатай үед явж өнгөрөх хэсгийн өндөр хийц бүтээц, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн доод гадаргуу хүртэл 4.2 м-ээс багагүй, харин гал унтраах тээврийн хэрэгсэлд 4.5 м-ээс багагүй байхаар төлөвлөх.</p> <p>3.3 Технологийн шаардлагаар тогтмол үзүүлэлттэй агаарын орчин барьж байх зориулалттай инженерийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ байрлуулах.</p> <p>3.4 Үйлдвэрийн барилгад байршуулах түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүний агуулах, мөн түүнчлэн ачааны налуу тавцанг холбогдох агуулахын барилгын норм ба дүрмийн шаардлагын дагуу төлөвлөх.</p> <p>3.5 Ачааны цахилгаан шат шаардлагатай талаар ТЭЗҮ боловсруулах явцад судлах, шаардлагатай тохиолдолд төлөвлөх.</p> <p>3.6 Хоёр ба түүнээс дээш давхарт тэргэнцэр ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөрлөх өрөө тасалгаатай тохиолдолд, нэгдүгээр давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг зохион байгуулах боломжгүй тохиолдолд зорчигчийн цахилгаан шат төлөвлөх. /Цахилгаан шатны бүхээгний өргөн - 1.1 м, гүн - 2.1 м, хаалганы нүхний өргөн 0.85 м-ээс багагүй байх/.</p> <p>3.7 Зоорийн давхраас гарах гарцыг өргөх, тээвэрлэх тоног төхөөрөмжийн ажиллах бүсээс гадуур төлөвлөх.</p> <p>3.8 Гонх болон дамжих гонхны өргөнийг хаалганы нүхний өргөнөөс 0.5 м (нүхний тал бүрээс 0.25 м)-ээс багагүй өргөсгөж, гүнийг нь хаалганы өргөнөөс 0.2 м-ээр ихэсгэж гэхдээ 1.2 м-ээс багагүй байхаар төлөвлөх. Тэргэнцэртэй хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд ажиллах хэсгийн гонх ба дамжих гонхны гүн 1.8 м-ээс багагүй байх.</p> <p>3.9 Гэгээвч, цонхны шилний цэвэрлэгээ ба засварт барилгын нийт өндөр эсвэл технологийн тоног төхөөрөмжийн байрлалын нөхцлөөс хамааран зөөврийн (зөөврийн шат, дүүжин талбай, агаарын /телекопический/ өргөгч) туслах хэрэгслийг ашиглах боломжгүй тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх нөхцлийг хангасан байнгын төхөөрөмжийг төлөвлөх. Эдгээр төхөөрөмжийг хэрэглэх үндэслэлийг технологийн хэсэгт гаргаж өгөх.</p> <p>3.10 Гэгээвч хийх шаардлага ба түүний төрлийг технологийн үйл ажиллагааны онцлог, барилга барих нутаг дэвсгэрийн цаг уурын нөхцөл, экологийн ба эрүүл ахуйн шаардлагаас хамааруулан сонгох.</p> <p>3.11 Гэгээвч нь салхины ачааллаас ангид байх ёстой. Гэгээвчийн урт 120 м-ээс ихгүй байна. Гэгээвчүүдийн хөндлөн тал хоорондын болон гадна хана, гэгээвчийн хөндлөн тал хоорондын зай 6 м-ээс багагүй байна. Гэгээвчний хавтсыг механикаар болон гар удирдлагаар онгойх боломжоор хангаж өгөх.</p> <p>3.12 Шатны хонгилд гишгүүрийн өргөн 0.3 м үед шатны налуу 1:2-оос багагүй байна. Адар болоод зоорийн давхарт гишгүүрийн өргөн 0.26 м үед шатны налуу 1:1.5 байх.</p> <p>3.13 Дотор задгай шат (шатны хонгилын хана байхгүй үед)-ны налуу 1:1-ээс ихгүй байх ёстой. Ганцаарчилсан ажлын байр луу очиход зориулагдсан задгай шатны налууг 2:1 хүртэл ихэсгэхийг зөвшөөрнө. Тоног төхөөрөмжийн үзлэгт зориулан 10 м-ээс илүүгүй өндөрт өгсөж гарах үед 0.6 м өргөнтэй босоо шат төлөвлөх.</p>
--	---



	<p>3.14 Тулгуур эрхтэний согогтой хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсадад зориулсан аврах зам гарц дахь шатны налуу 1:2-оос ихгүй байх шаардлагатай.</p> <p>3.15 Газрын төлөвлөлтийн түвшинээс мөг (карниз), эсвэл дээврийн хашлага ханын дээд тал хүртэл 10 м ба түүнээс илүү өндөр барилгын дээвэрт гарах гарц (дээврийн бүрэн ба бүрэн бус 40000 м² тутамд нэгийг) төлөвлөнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -нэг давхар барилгад- гадна төмөр шатаар -олон давхар барилгад- шатны хонгилоор гарах гарц төлөвлөх. - Бохир гадагшлуулах ариутгах татуургын шугам төлөвлөх шугам бүрт шүүн тунгаах механик ба автомат тоноглолоор тоноглох. ТЭЗҮ-ээр нарийвчлан тогтоох - Шаардлагатай усан хангамжийг шугам сүлжээг төлөвлөх. - Саарал ус буюу цэвэрлэхээс гарсан усыг эргүүлэн ашиглах шугам сүлжээ төлөвлөх. Эдийн засгийн үр ашгийг ТЭЗҮ боловсруулах явцад тооцож шугам сүлжээ төлөвлөх талаар захиалагчтай зөвшилцөх - Дулаан хангамжийн болон үйлдвэрийн халуун усны хэрэглээний шугам төлөвлөх. - Цахилгаан хангамж төлөвлөх - Агааржуулалтын систем тооцож төлөвлөх. <p>Суурь: Барилгын суурийг төмөрбетонон баганан болон төмөрбетонон угсармал аяган суурь хийх, тоног төхөөрөмжүүдийн суурийг хүндийн жин, динамик, статик хүчний үйлчлэлээс нь хамааруулан суурийг тус тус тооцсон байх. Тоног төхөөрөмжийн суурийн зургийг техник эдийн засгийн үндэслэл, технологийн байгуулалт зэргийг үндэслэн нарийвчлан зурах. Тоног төхөөрөмжийн сонголтыг ТЭЗҮ боловсруулах явцад захиалагч талтай зөвшилцөх</p> <p>Шал: W6 маркын ус шингэлт багатай байхаас гадна пуццолон портландцемент, шлакан портландцемент хэрэглэх /эсвэл чанарын ижил түвшиний материал ашиглах/ нь хүчил шүлтийн үйлчлэлд тэсвэртэй байна. Арматурын хамгаалалтын үеийг 50мм түүнээс дээш авах нь тохиромжтой. Шалны гадаргууг химийн элементүүдээс хамгаалах зорилгоор шингэн шилийг нэвчүүлж давтан түрхсэн байх шаардлагатай эсвэл чанарын шаардлага хангасан ижил төстэй материал ашиглах.</p> <p>Хана: Олон үетэй төмөр бетонон ханын хавтан эсвэл хөнгөн дүүргэгчтэй гадна ханын хавтгайлж сонгох нь тохиромжтой /эсвэл чанарын хувьд ижил буюу түүнээс дээш зэргийн материалаар хийх/ бөгөөд арматурын хамгаалалтын үеийг ердийн эдлэлийнхээс өндрөөр авна. /50мм- дээш/ Ханын дулаалгад хөөсөн перлит, керамзит зэрэг байгалийн гаралтай барилгын материал ашиглах нь эдэлгээний хувьд давуу талтай. Дотор ханыг шингэн шил эсвэл орлох материалаар нэвчүүлэн хамгаалалт хийхийг ажлын зурагт тусгах. ТЭЗҮ боловсруулах явцад хийц эдлэлийг сонгож захиалагч талтай зөвшилцөх.</p> <p>Тааз: Үйлдвэрийн барилгын хучилтын үндсэн бүтээцийг W6 маркын ус шингэлт багатай пуццолон портландцемент, шлакан портландцементэн барьцалдуулагчтай төмөрбетон эдлэл эсвэл орлож чадах хийц элемент байна. Төмөрбетон хучилт ба төмөрбетон эдлэлд сонгосон тохиолдолд ус чийгний тусгаарлагч заавал хийсэн байх шаардлагатай. Хучилтыг ус, чийг, уурын</p>
--	--



		үйлчлэлд тэсвэртэй хөнгөн, эдэлгээ удаан, эдийн засгийн хувьд өгөөжтэй байхаар төлөвлөж тусгах
8	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; <p>Стандартууд:</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсад хэрэглэж байгаа хүлээн зөвшөөрөгдсөн норм дүрэм - Түүхий эдийн бэлтгэл. Арьс шир. Чанарын хамгаалалт хийх аргууд MNS 5094:2013 - Түүхий эдийн төрөлжсөн захын ангилал. Ерөнхий шаардлага. MNS 5245:2008 - Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. MNS 4244:94 - Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Цахилгааны аюулгүй байдал. Ерөнхий шаардлаг. MNS 5150:2002 - Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага. Ангилал MNS 4931:2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 - Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Ачиж буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079:2001 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2000 - Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 4244:94 - Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага. MNS 4244:94. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага. MNS 996:2000. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага. MNS 4968:2000. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2000. - Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5078:2001. - Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын урсгалын хурдыг хэмжих арга. MNS 5077:2001. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Шуугианы норм. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS 5002:2000. - Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага. MNS 4930: 2000. - Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага, ангилал. MNS 4931: 2000. - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын шошго тэмдэглэгээ. MNS 5029:2001. - Усан мандал. Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS (ISO) 3342:1982. - Усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл. MNS 4236:1994.

		<ul style="list-style-type: none"> - Барилгын зураг. Дотор усан хангамж, ариутгах татуурга, хийн хангамжийн системийн элементүүдийг дүрслэх. MNS 3332:1982. - MNS 3989 -1987 Орон сууц, олон нийтийн барилгын гадна ханын бетон, төмөр бетон хавтгайлж. <p>Норм норматив</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын Дэд бүтцийн сайдын 2003 оны 252 тоот тушаалаар батлагдсан "Захиргаа, аж ахуйн барилга" БНБД 31-04-03. - Үйлдвэрийн барилга байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм ба дүрэм. БНБД 2.09.12-18. - Барилгын инженер геологийн ажил БНБД 11-03-01 - Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНБД 11-07-04 - Барилгын геодизийн ажил БНБД 11-08-06 - Инженерийн шугам сүлжээний зураглал хийх БНБД 11-105-06 - Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-04 - Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БНБД 12-01-09 - Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-01-14 - Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04 - Цутгамал бетон, төмөр бетон бүтээц БНБД 3.03.01-88 - Угсармал төмөр бетон бүтээц БНБД 3.03.02-90 - Барилгын засварын ажлын төсвийн суурь норм - Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23.01.09/ - Бусад хууль тогтоомж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм, норматив баримт бичиг, төсөл хөтөлбөр, дүрэм журмыг дагаж мөрдөнө. <p>Төсөл, хөтөлбөрүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хотын эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд болон бусад холбогдох төсөл хөтөлбөрүүд
9	Ажлын зураг төслийн бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Байршлын схем М1:5000 - Байр зүйн зураглал UTM84; М1:500- М1:1000 - Техникийн зураг төсөл - Ажлын зураг төсөл - Инженер, геологийн дүгнэлт - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт улаан шугам - Төслийн бүсийн хур тундасны судалгаа, (олон жилийн дундажаар), болзошгүй үерийн аюулын тооцоо - Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн судалгаа, дүгнэлт - Тогтворжсон горимын тооцоо, оновчтой хувилбар сонгох - Ерөнхий дүгнэлт, тайланг мэргэжлийн төрийн захиргааны байгууллагаар хянуулж батлуулах - Зураг төслийн баримт бичиг нь Монгол, Англи хэл дээр 4 хувь. Үүнээс: график зураглал DVD-ны хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө.
10	Инженерийн хангамж	Тухайн байгууламжаас хамаарах хамааралыг судлах, техникийн нөхцөл гаргах ажлыг оновчтой зохион байгуулах
11	Архитектурын төлөвлөлтөнд	Архитектур төлөвлөлтийн шийдлийг хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу гүйцэтгэх



	тавигдах шаардлага	Нийгмийн дэд бүтэц, хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, норм дүрмийн дагуу хүчин чадлыг нарийвчлан тогтоох
12	Эдийн засгийн тооцоо, төсөв	Эдийн засгийн тооцоо болон төсвийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно.
13	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 6 сар
14	Зураг төсөл боловсруулах байгууллага	Зөвлөх үйлчилгээний эрх бүхий хуулийн этгээд
15	Санхүүжилт	265,000,000.00 (Хоёр зуун жаран таван сая төгрөг)
16	Санхүүжилтийн эх үүсвэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
17	Төслийн захиалагч	"Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
18	Гүйцэтгэгч байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан хуулийн этгээд
19	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гаргах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ технологи хэрэглэх гэх мэт)	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн барилга угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. - Дэвшилтэт техник технологийн шийдлийг тусгасан "хэмнэлттэй", ногоон төлөвлөлтийн үндсэн зарчмуудыг агуулсан, тухайн бүс нутгийн болон байгаль цаг уурын онцлогт зохицсон төлөвлөлтийн шийдэл бүхий хувилбаруудын жишиг загвар зургийг томсгосон өртгийн хамт боловсруулах. - ТЭЗҮ -д Баянхонгор аймаг болон зэргэлдээх бүс нутгийн түүхий эдийн тооцоог нарийвчлан гаргаж хүчин чадлыг эцэслэн тогтоох.
20	Ажлын даалгаварт тусгагдаагүй бусад ажил	- Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлтээр гүйцэтгэж болох бөгөөд гэрээний тусгай нөхцөлд тусгасны дагуу зохицуулна.
21	Хүлээн авах баримт	- Ажлын иж бүрдэл хэсэгт туссан судалгаа шинжилгээ, зураглал, тайлан, тооцоо, видео зэргийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн программ хангамжийн эх хувилбараар "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ-т хүлээлгэж өгөх /4 хувь/.